

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/57/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5.1 Төлбөрийн акт	19
5.1 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсвийн үйлдвэрийн газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.24 № 2/99

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Жаргалант сумын сургуулийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 210 тоо толгой хонийг 13,230.3 мянган төгрөгөөр борлуулах, 1,520.0 мянган төгрөгийн 13 тоо толгой хонийг акталж устгахдаа сургуулийн захирал, байгууллагын өмч хамгаалах зөвлөл холбогдох шийдвэрүүдийг гаргаагүй;
- БШУС-ын 2022.11.08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар хувьсах зардлаас тоног төхөөрөмжийн нөхөн хангалтад олгосон 37,465.0 мянган төгрөгийн санхүүжилтээс ерөнхий гэрээ байгуулаагүй "Тэнгэрийн уул" ХХК, "Арина компьютерс" ХХК, "Алтанбулаг үржих" ХХК-аас 13,361.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө худалдан авах гэрээ байгуулалгүйгээр худалдан авсан;
- Эд хөрөнгийн тооллогын дүнг нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, сургуулийн захирлын 2022.06.15-ны өдрийн 46 дугаар тушаалаар 6,385.4 мянган төгрөгийн бараа материал актлах шийдвэр гарсан ч бараа материалыг устгасан акт үйлдээгүй;
- Сургуулийн захирлын 2022.12.15-ны өдрийн 102 дугаар тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай түвшнээр үнэлэгдээгүй сургуулийн сургалтын менежер,

багш нар, нийгмийн ажилтан зэрэг 23 албан хаагчдад 4,136.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон

- Сургуулийн албан хаагчдад 21,852.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгох, аймаг, нийслэл рүү сургалтын зардалд шатахууныг олгохдоо сургуулийн захирал тушаал шийдвэр гаргаагүй, сургуульд тээврийн хэрэгсэл байхгүй, тээвэр шатахууны зардал батлагдаагүй байхад 7,986.2 мянган төгрөгийн шатахууныг “НИК” ХХК-д шилжүүлэн олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-73 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална...”, 14.4 дэх “14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, 15.2.3 дахь “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалт УСНББОУС 17, УСНББОУС 19, болон Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2022 онд 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд 1,365,538.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, өөрийн орлогын төлөвлөгөө 23,205.3 мянган төгрөгөөр тасарч, гүйцэтгэлээр 1,316,731.1 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 1,222.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 24,379.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Дээд шатны байгууллагын шийдвэрээр 2022 оноос ерөнхий боловсролын сургуулиуд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжиж, багшийн цахим хэрэглээ, эрүүл мэндийг дэмжих зардлуудыг төсвөөс олгосон, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 119,000.0 мянган төгрөгөөр сургуулийн гал тогооны их засварыг хийж гүйцэтгэсэн байна.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд бүртгэлтэй мал амьтныг холбогдох шийдвэргүйгээр акталж, худалдан борлуулсан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг мөрдөөгүй, эд хөрөнгийн тооллогын дүнг нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, устгасан бараа материалын

устгалын актыг үйлдээгүй, гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх ба БШУЯ-наас үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээгээр 11 багш 1-4 дүгээр түвшинд, Жаргалант сумын сургууль 4 дүгээр түвшинд үнэлэгдсэн байна.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго, 9 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Жаргалант сумын Засаг дарга 96.9 хувиар үнэлсэн байна.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>140,931,883.24</u>	<u>156,441,144.80</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	24,379,869.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	24,379,869.00
3121	Төгрөг	00.00	24,379,869.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	24,379,869.00
33	АВЛАГА	439,520.00	433,775.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	439,520.00	433,775.00
35	БАРАА МАТЕРИАЛ	140,492,363.24	131,627,500.80
351	Түүхий эд материал	13,187,790.00	9,961,640.00
35110	Тусгай зориулалттай материал	7,826,940.00	7,826,940.00
35130	Эм боох материал	5,360,850.00	2,134,700.00
354	Хангамжийн материал	101,784,573.24	109,765,860.80
35410	Бичиг хэргийн материал	444,100.00	980,700.00
35420	Аж ахуйн материал	81,938,236.24	81,657,097.24
35440	Түлш, шатах тослох материал	1,526,000.00	1,280,000.00
35450	Барилгын засварын материал	12,600,100.00	12,532,600.00
35460	Хүнсний материал	471,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	4,805,137.00	13,315,463.56
35600	Мал амьтад	25,520,000.00	11,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,253,708,435.26</u>	<u>1,484,713,044.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,253,708,435.26	1,484,713,044.13
392	Биет хөрөнгө	1,235,069,435.26	1,452,088,419.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,379,935,769.10	1,498,935,769.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-295,830,606.15	-318,857,538.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	227,343,435.13	368,603,197.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-167,368,510.77	-180,745,384.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,910,721.95	119,910,721.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-73,899,490.35	-80,736,462.92
39217	Ном	44,978,116.35	44,978,116.35
393	Биет бус хөрөнгө	18,639,000.00	32,624,625.04
39301	Програм хангамж	425,000.00	425,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-184,374.96
39303	Бусад биет бус хөрөнгө	18,364,000.00	32,384,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,394,640,318.50</u>	<u>1,641,154,188.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>330,739.00</u>	<u>59,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	330,739.00	59,500.00
413	Өглөг	330,739.00	59,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	330,739.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	59,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,394,309,579.50</u>	<u>1,641,094,688.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,394,309,579.50	1,641,094,688.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	492,188,069.70	492,188,069.70
51101	Өмч: - төрийн	492,188,069.70	492,188,069.70
512	Хуримтлагдсан үр дүн	-182,520,425.04	64,264,684.39
51210	Өмнөх үеийн үр дүн	-182,520,425.04	-182,520,425.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	246,785,109.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,084,641,934.84	1,084,641,934.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,394,640,318.50</u>	<u>1,641,154,188.93</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,132,461,597.00	1,690,856,735.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,555,005.00	296,010,226.56
120	Нийтлэг татварын бус орлого	28,555,005.00	295,348,748.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	15,821,739.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,260,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	13,230,300.00
120009	Бусад орлого	00.00	835,739.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,074,592.00	1,395,177,248.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,168,233,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	958,832,000.00	1,168,233,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,838,635.00	68,340,048.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,796,985.00	68,340,048.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,041,650.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,235,957.00	158,604,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,235,957.00	158,604,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,121,673,747.01	1,444,071,626.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,121,673,747.01	1,425,206,626.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,054,996,561.01	1,289,570,388.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	737,555,088.00	883,925,449.00
210101	Үндсэн цалин	675,614,274.00	807,811,128.00
210104	Урамшуулал	61,940,814.00	35,512,362.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	40,601,959.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,356,257.00	110,648,641.00
210201	Тэтгэврийн даатгал	68,026,993.00	70,713,467.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,519,717.00	13,937,749.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,998,976.00	7,111,722.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,437,325.00	1,716,883.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,373,246.00	17,168,820.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,949,747.00	113,497,601.00
210301	Гэрэл, цахилгаан	4,358,747.00	9,997,601.00
210302	Түлш, халаалт	96,392,500.00	103,050,000.00
210303	Цэвэр, бохир ус	198,500.00	450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,452,193.73	59,990,589.00
210401	Бичиг хэрэг	3,717,867.00	7,284,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,755,150.00	7,986,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,558,680.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	386,124.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,077,652.73	12,413,950.00
210408	Бараа материал акталсны зардал	6,216,720.00	7,905,489.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	8,740,000.00	24,400,000.00
2105	Нормативт зардал	28,536,370.00	49,772,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,574,700.00	3,226,150.00
210502	Хоол, хүнс	21,729,320.00	46,546,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	232,350.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,835,110.00	6,147,400.00
210604	Урсгал засвар	7,835,110.00	6,147,400.00
2107	Томилолт, зочны зардал	452,000.00	314,600.00
210702	Дотоод албан томилолт	452,000.00	314,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,793,386.00	8,060,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,263,386.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,000.00	8,060,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,066,409.28	57,213,038.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	13,937,885.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,066,409.28	43,275,153.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,677,186.00	135,636,238.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,898,868.00	134,413,976.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,182,030.00	55,563,495.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,590,968.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,630,870.00	68,340,048.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	495,000.00	10,510,433.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,011.00	1,222,262.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,222,262.00
213404	Хөрөнгийн	1,011.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,777,307.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,777,307.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	18,865,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	18,865,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	18,865,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,787,849.99	246,785,109.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,787,849.99	246,785,109.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,103,906,592.00	1,411,503,987.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	16,657,478.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	15,996,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	15,821,739.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,260,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	13,230,300.00
120009	Бусад орлого	00.00	835,739.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,103,906,592.00	1,395,177,248.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,168,233,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	958,832,000.00	1,168,233,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,838,635.00	68,340,048.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,796,985.00	68,340,048.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,041,650.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,235,957.00	158,604,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,235,957.00	158,604,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,070,755,192.00	1,347,189,478.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,070,755,192.00	1,347,189,478.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,004,078,006.00	1,211,553,240.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,265,916.00	883,972,158.00
210101	Үндсэн цалин	582,118,078.00	646,927,334.00
210102	Нэмэгдэл	110,415,796.00	180,052,700.00
210104	Урамшуулал	45,732,042.00	18,523,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	38,468,724.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,664,123.00	110,926,926.00
210201	Тэтгэврийн даатгал	70,546,455.00	75,566,670.00

210202	Тэтгэмжийн даатгал	6,279,397.00	8,932,368.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,023,602.00	7,137,219.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,255,883.00	1,786,094.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,558,786.00	17,504,575.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,236,047.00	113,192,101.00
210301	Гэрэл, цахилгаан	5,645,047.00	9,997,601.00
210302	Түлш, халаалт	96,392,500.00	102,744,500.00
210303	Цэвэр, бохир ус	198,500.00	450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,527,004.00	00.00
210401	Бичиг хэрэг	948,500.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,191,250.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,618,680.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	811,724.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956,850.00	00.00
2105	Нормативт зардал	31,313,770.00	46,075,420.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,113,900.00	00.00
210502	Хоол, хүнс	20,966,120.00	46,075,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,233,750.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,305,710.00	1,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	447,600.00	00.00
210604	Урсгал засвар	8,858,110.00	1,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	452,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	452,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,296,386.00	10,821,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,766,386.00	2,760,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,000.00	8,060,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,017,050.00	44,865,435.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,600,000.00	32,734,735.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,417,050.00	12,130,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,677,186.00	135,636,238.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,898,868.00	134,413,976.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,182,030.00	55,563,495.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,590,968.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,630,870.00	68,340,048.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	495,000.00	10,510,433.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,011.00	1,222,262.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,222,262.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,777,307.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,777,307.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,151,400.00	64,314,509.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,151,400.00	39,934,640.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,151,400.00	39,934,640.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,151,400.00	39,934,640.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,151,400.00	39,934,640.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-33,151,400.00	-39,934,640.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	24,379,869.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	24,379,869.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	-182,520,425.04	1,394,309,579.50
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	-182,520,425.04	1,394,309,579.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	-182,520,425.04	1,394,309,579.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	246,785,109.43	246,785,109.43
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	64,264,684.39	1,641,094,688.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,365,538,500.00	1,316,731,069.00	48,807,431.00	96.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,365,538,500.00	1,316,731,069.00	48,807,431.00	96.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,290,351,100.00	1,250,657,141.00	39,693,959.00	96.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	894,273,500.00	883,972,158.00	10,301,342.00	98.85
210101	Үндсэн цалин	657,089,000.00	646,927,158.00	10,161,842.00	98.45
210102	Нэмэгдэл	180,052,700.00	180,052,700.00	00.00	100.00
210104	Урамшуулал	18,523,400.00	18,523,400.00	00.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,608,400.00	38,468,724.00	139,676.00	99.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,084,600.00	110,596,187.00	488,413.00	99.56
210201	Тэтгэврийн даатгал	75,313,700.00	75,235,931.00	77,769.00	99.90
210202	Тэтгэмжийн даатгал	8,942,800.00	8,932,368.00	10,432.00	99.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,154,200.00	7,137,219.00	16,981.00	99.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,788,500.00	1,786,094.00	2,406.00	99.87
210205	Эрүүл мэндийн даатгал	17,885,400.00	17,504,575.00	380,825.00	97.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,169,600.00	113,192,101.00	977,499.00	99.14
210301	Гэрэл, цахилгаан	10,895,100.00	9,997,601.00	897,499.00	91.76

210302	Түлш, халаалт	102,824,500.00	102,744,500.00	80,000.00	99.92
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	450,000.00	00.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,000,000.00	00.00	20,000,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,000,000.00	00.00	20,000,000.00	00.00
2105	Нормативт зардал	49,639,200.00	46,075,420.00	3,563,780.00	92.82
210502	Хоол, хүнс	49,639,200.00	46,075,420.00	3,563,780.00	92.82
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,700,000.00	1,700,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	1,700,000.00	1,700,000.00	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,347,900.00	10,321,200.00	26,700.00	99.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,260,700.00	2,260,700.00	00.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,087,200.00	8,060,500.00	26,700.00	99.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89136300.00	84800075.00	4,336,225.00	95.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,005,500.00	72,669,375.00	4,336,125.00	94.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,130,800.00	12,130,700.00	100.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75187400.00	66073928.00	9,113,472.00	87.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,187,400.00	66,073,928.00	9,113,472.00	87.88
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,673,900.00	55,563,495.00	9,110,405.00	85.91
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,513,500.00	10,510,433.00	3,067.00	99.97
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,365,538,500.00	1,342,333,200.00	23,205,300.00	98.30
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,168,233,200.00	1,168,233,200.00	00.00	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,168,233,200.00	1,168,233,200.00	00.00	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	158,604,000.00	158,604,000.00	00.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	158,604,000.00	158,604,000.00	00.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	38,701,300.00	15,496,000.00	23,205,300.00	40.04
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,260,700.00	2,260,700.00	00.00	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,440,600.00	13,235,300.00	23,205,300.00	36.32
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	64.00	62.00	2	96.88
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	45.00	1	97.83
620003	Үйлчлэх ажилтан	17.00	16.00	1	94.12
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	531.00	528.00	3	99.44
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	531.00	528.00	3	99.44
630001	Төрийн өмчит ЕБС	531.00	528.00	3	99.44
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	64.00	62.00	2	96.88
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	47.00	46.00	1	97.87
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	16.00	1	94.12

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,840,048.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,840,048.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68340048.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,340,048.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	68,340,048.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	68340048.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,340,048.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,340,048.00

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалант сумын ЕБС нь "Хүүхдийн сурах тэгш боломжийг бүрдүүлж, суралцахуйн хоцрогдлыг арилгаж, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцож, ээлжит хичээлийн цахим контент байрлуулах" эрхэм зорилготой тус сургууль нь 2022 онд 7 зорилт дэвшүүлж, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захиргаа аж ахуй, Нийгмийн ухаан, Байгалийн ухаан, Бага ангийн заах аргын нэгдэл гэсэн бүтэц зохион байгуулалттай 62 орон тоотой, 528 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Б.Саранцэцэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Өлзийбуян нар зурж, нярваар Я.Цогтбаатар нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;
- Төрийн албаны зөвлөлийн 2022.11.14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор бүх албан хаагчдын хувийн хэрэг шинэчилсэн;
- Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор хичээл сургалтын үйл ажиллагаа, багш ажиллагсдын тасралтгүй хөгжлийг дэмжих, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлыг тус тус хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг томилсон;
- БШУС-ын 2022.05.12-ны өдрийн 170 дугаар тушаалын дагуу 4 ажлын хэсгийг байгуулсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 246,513.9 мянган төгрөгөөр буюу 17.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	24,379.9	24,379.9
Авлага	439.5	433.8	(5.7)
Бараа материал	140,492.4	131,627.5	(8,864.9)
Үндсэн хөрөнгө	1,790,957.0	2,065,236.8	274,279.8
Хуримтлагдсан элэгдэл	(537,248.6)	(580,523.8)	(43,275.2)
Нийт хөрөнгө	1,394,640.3	1,641,154.1	246,513.8
Өр төлбөр	330.7	59.5	(271.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,394,309.6	1,641,094.7	246,785.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,394,640.3	1,641,154.2	246,513.9

Эх сурвалж: Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд 64 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 62 орон тоотой ажилласнаас цалин, НДШ-ийн зардал 10,650.2 мянга, байр ашиглалттай холбоотой түлш халаалт, гэрэл цахилгааны зардал 977.5 мянга, хүүхэд өдрийн гүйцэтгэлээс шалтгаалж үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 12,674.2 мянган төгрөгөөр хэмнэгдэж, оны эцэст харилцах дансанд 24,379.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сургуулийн захирлын 2022.06.15-ны өдрийн 46 дугаар тушаалаар нийт 32,305.5 мянган төгрөгийн бараа материал акталснаас өмнөх оноос бараа материал буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн хөрөнгөөр 39,934.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 119,000.0 мянган төгрөгөөр сургуулийн гал тогооны их засвар хийснийг орлогод авсан, БШУЯ-аас дижитал танхим бүрдүүлэхэд 64,944.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 36,380.8 мянган төгрөгийн 16 ширхэг зөөврийн компьютер хандиваар ирсэн, төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогоор байгууллагын харьяаны 4 газрыг зөрүүтэй бүртгэснийг залруулж бүртгэн нэмж 14,020.0 мянган төгрөгийн газрын бүртгэснээр сургуулийн үндсэн хөрөнгө өмнөх оноос 274,279.7 мянган төгрөгөөр нэмэгдэх шалтгаан болжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 246,785.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 492,188.1 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 294,666.7 мянган төгрөгөөр нэмэгдэн 1,641,094.7 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,121,899.8 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 217,585.7 мянга, нийт 1,339,485.5 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжих зардлыг 199,089.3 мянган төгрөгөөр хасаж, 1,140,396.2 мянган төгрөгөөр баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу томилолт, бичиг хэрэг, бусад зардлуудыг хасаж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг дээд шатны байгууллагаас 2022 оны 5 дугаар сард төсвийг цалингийн шатлал нэмэгдсэнтэй холбоотой улсын төсвөөс санхүүжих дүнг 103,576.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 9 дүгээр сард гэрээт ажлын хөлс, НДШ-ийн зардлыг 52,100.0 мянган төгрөгөөр бууруулжээ. Тайлант оны 12 дугаар сард цалин, НДШ-ийн зардлыг 64,390.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, БШУЯ-аас хийсэн гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой урамшууллын болон нөхөн хангалтын зардлыг баталж, оны эцэст нийт төсвийг 1,365,538.5 мянган төгрөгөөр баталж, үүнээс өөрийн орлогоор 38,701.3 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,168,233.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1,143,852.3 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 24,379.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 158,604.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.2 хувь буюу 157,381.7 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 1,222.3 мянган төгрөгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ / 80226 /	3,234.9	3,229.5	5.4	99.8%
2	Сургалтын семинар / 80312 /	1,617.4	1,611.0	6.4	99.6%
3	Эрүүл мэндийг дэмжих / 81605 /	3,720.1	3,692.5	27.6	99.2%
4	Үдийн цай хөтөлбөр / 81801 /	64,673.9	55,563.5	9,110.4	85.9%
5	Дотуур байрны үйлчилгээ / 81806 /	66,914.3	60,899.1	6,015.2	91.0%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин / 81816 /	37,465.0	37,464.6	0.4	100.0%
7	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх /81823/	7,278.5	7,278.5	0.1	100.0%
8	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн / 81834 /	849,515.5	843,941.3	5,574.2	99.3%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа / 81835 /	133,813.6	131,233.4	2,580.2	98.0%
10	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн үйлчилгээ / 81844 /	36,440.6	12,175.3	24,265.3	33.4%
11	Сурах бичгийн түрээс / 81848 /	2,260.7	2,260.7	-	100.0%
12	Нийтлэг үйлчилгээ /80112/	158,604.0	157,381.7	1,222.3	100.0%
Дүн		1,365,538.5	1,316,731.1	48,807.4	

Эх сурвалж: Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 5 жилд нэг удаа олгох тэтгэмжийн санхүүжилтийн 68,340.0 мянган төгрөгийг сургуулийн захирлын 2022.02.24-ний өдрийн 17 дугаар тушаалаар 14 багшид олгосон байна.

НҮБ-ийн Хүүхдийн сангийн Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус, ариун цэврийн байгууламжийн төслийн уралдаанд тус сургуулийн 2 багш, 2 сурагч 500.0 мянган төгрөгийн төсөл бичиж оролцон шалгарч, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга, Жаргалант сумын ЕБС-ийн захирал нар 2022.04.25-ны өдөр байгуулсан гэрээний дагуу Дэлхийн усны өдрийг сурталчлах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулахад зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-аас суурилуулсан интернэтийг ашиглах, эд хөрөнгийн тооллогын үр дүнг тооцож, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдэж байх, эд хөрөнгийг устгасан тухай акт үйлдэж, анхан шатны баримтад хавсаргаж байх, эд хөрөнгийн ангилал, ашиглах хугацааг залруулж бүртгэх, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах холбогдох шийдвэрийг тухай бүр гаргаж байх, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст гэрээ, орхигдуулсан орлогыг нөхөн байршуулах сэргийлэх зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.12.09-ны өдрийн 112 дугаар албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,365,538.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 20,483.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 14,338.2 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын Ерөнхий газраас албан бичиг ирүүлсэн, тайлант онд 2 орон тоо дутуу ажилласнаас цалин, НДШ-ийн зардал 10,650.2 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 977.5 мянга, хүүхэд өдрийн гүйцэтгэлээс шалтгаалж үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 12,674.2 мянган төгрөгөөр хэмнэгдэж, оны эцэст 2,209.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, зарцуулаагүй үлдэгдэл харилцах дансанд үлдэгдлээр байна.

Жаргалант сумын ЕБС-ийн халаалтын зардлын гүйцэтгэл өмнөх оноос 6,352.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сургуулийн хичээлийн байрын дутуу ашиглаж байсан хэсгийг урсгал засварыг хийж, халаалтыг нэмсэнтэй холбоотой 2022 оны 9 дүгээр сарын сүүлчээр халаасантай холбоотой түлш халаалтын зардал нэмэгдсэн байна. Сургуулийн гал тогооны их засвар хийгдэж, тоног төхөөрөмжийн хүчин чадал нэмэгдсэн, цахилгааны үнийн тариф өссөнтэй холбоотой гэрэл цахилгааны зардал өмнөх оноос 4,352.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,325,618.4 мянган төгрөгийн 46 гүйлгээ, зарлагын 241,987.2 мянган төгрөгийн 26 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 125,168.7 мянган төгрөгийн 9 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин тайлант оны 10 дугаар сарын 5,500.0 мянган төгрөгийн малын үнэ болон аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 203,494.6 мянган төгрөгийн 5 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 5,500.0 мянган төгрөгийн орлого болон гэрээнүүдийг нөхөн байршуулах зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, 79.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, менежментийн захидлаар үнийн дүнгүй 2 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	79.2	1	79.2	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	0	2	0	50%
Нийт дүн	3	79.2	3	79.2	75%

Эх сурвалж: Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022.05.25-ны өдрийн 46 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2022.05.25-ны өдөр 46 дугаар албан бичгээр ирүүлсэн, төлбөрийн актыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харин шилэн дансны цахим хуудаст мэдээллийг байршуулах, хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй, өмнөх жил гарсан зөрчил давтагдсан ба УАГ-аас өгсөн чиглэлийн дагуу бага хувийг эзэлсэн тул зөвлөмж өгөв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын туслах аж ахуйг хариуцсан малчин байхгүй, тэтгэвэрт гарсан байгаа тул дараагийн аудитаар мал аж ахуйн орлогыг тодруулан үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 77,797.0 мянган төгрөгийн 11 зөрчил¹ илэрснээс 4,635.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 28,111.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 45,049.4 мянган төгрөгийн дүн бүхий 6 зөвлөмжийг менежментийн захидлаар өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

1. Санхүүгийн тайланд хичээлийн зохицуулагчаар ажиллаж байгаад нас барсан иргэнтэй холбоотой 2019 онд үүссэн 387.1 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй ба байгууллагын дотоод журамд заасны дагуу ажлаас гарч байгаа албан хаагчтай тооцоог тухай бүр хийгээгүй, тус авлагыг барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн тул сургуулийн нягтлан бодогчоор нөхөн төлүүлэн, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Сургуулийн захиралд эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр, өөртөө интернэтийн зардал олгох шийдвэр гаргаж, 2022 онд 112.0 мянган төгрөгийг төсвөөс олгосон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн тул сургуулийн захирлаар зардлыг нөхөн төлүүлж, орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Сургуулийн захирлын 2022.12.15-ны өдрийн 102 дугаар тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай түвшнээр үнэлэгдээгүй сургуулийн сургалтын менежер, багш, нийгмийн ажилтан зэрэг 23 албан хаагчдад ур чадварын нэмэгдэлд 10-25 хувиар тооцож, 4,136.6 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална...”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг зөрчсөн тул 2022 оны 12 дугаар сард ур чадварын нэмэгдэл авсан төрийн үйлчилгээний албан хаагчдаас бусад албан хаагчдаар нөхөн төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.1 Албан шаардлага

1. БШУС-ын 2022.11.08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтад олгосон 37,465.0 мянган төгрөгийн санхүүжилтээс ерөнхий гэрээний дагуу "Техно зон" ХХК-аас 24,273.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, ерөнхий гэрээ байгуулаагүй "Тэнгэрийн уул" ХХК, "Арина компьютерс" ХХК, "Алтанбулаг үржих" ХХК-аас 13,361.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө худалдан авах гэрээ байгуулалгүйгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэснийг зөрчсөн тул цаашид хууль, тогтоомжийн дагуу худалдан авалтыг зохион байгуулж, гэрээ байгуулан, хөрөнгө хүлээн авсан тухай актыг үйлдэж байх албан шаардлага өгөв.

2. Жаргалант сумын сургуулийн санхүүгийн тайланд оны эхэнд 253 тоо толгой хонь бүртгэлтэй, 2022 онд 117 тоо толгой төл орлогод авсан ба тайлант онд 210 тоо толгой

хонийг 13,230.3 мянган төгрөгөөр борлуулах, 1,520.0 мянган төгрөгийн 13 тоо толгой хонийг акталж устгахдаа сургуулийн захирал, байгууллагын өмч хамгаалах зөвлөл холбогдох шийдвэрүүдийг гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгаж, алдааг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: БШУС-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд баримтлах чиглэлийн 5-д "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас бүх сургууль, цэцэрлэгийн интернэтийн төлбөрийг төлсөн, интернэтийн төлбөрийг давхардуулан төлж, үр ашиггүй зардал гаргасан байх" асуудлыг ирүүлснийг тодруулан шалгахад тус интернэтийн хурд, хүчин чадал шаардлага хангахгүйгээс ашиглах боломжгүй гэсэн шалтгаанаар 2022 онд үүрэн гэр интернэтийн төлбөрт 3,125.0 мянган төгрөгийг давхардуулан төлсөн байна.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас суурилуулсан интернэтийг бүрэн ашиглаж, бусад байгууллагуудад интернэтийн төлбөрийг давхардуулан төлөхгүй байх

2. Дотуур байрны хүүхдийн хоолны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд сургуулийн дотуур байрны 13409 хүүхэд өдөрт 46,596.3 мянган төгрөгийн зардал олгохоор байхад 46,546.4 мянган төгрөгийг олгож, баталсан нормативыг хэтрүүлснээс төсвөөс тус зардалд 49.8 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид тогтоосон нормативыг баримталж ажиллаж, 2022 онд илүү олгосон 49.8 мянган төгрөгийн зардлыг бусад татвар хураамжийн 100030000947 тоот дансанд 2023.05.10-ны дотор төвлөрүүлэх

3. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эд хөрөнгийн тооллогын дүнг нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, сургуулийн захирлын 2022.06.15-ны өдрийн 46 дугаар тушаалаар 6,385.4 мянган төгрөгийн бараа материал актлах шийдвэр гарсны дагуу бараа материалыг актлахдаа устгалын акт үйлдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 73 дугаар зүйлийн 73.2 дахь "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэснийг мөрдөж, бараа материалын устгалын актыг тухай бүр үйлдэж, анхан шатны баримтад хавсаргаж байх

4. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны 10 дугаар сарын 5,500.0 мянган төгрөгийн малын үнэ болон аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 203,494.6 мянган төгрөгийн 5 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан, таван сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий орлого, зарлагыг мэдээлсэн, зарим тушаалын хавсралтыг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг үнэн зөв, бүрэн байршуулах, иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг тухай бүр байршуулах, орхигдуулсан орлогыг нөхөн мэдээлэх

5. Сургуулийн албан хаагчдад тайлант онд 21,852.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгох, аймаг, нийслэл рүү сургалтын зардалд шатахууныг олгохдоо сургуулийн захирал тушаал шийдвэр гаргаагүй, сургуульд тээврийн хэрэгсэл байхгүй, тээвэр шатахууны зардал батлагдаагүй байхад 7,986.2 мянган төгрөгийн шатахууныг 2022 онд олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, тогтоомжийг мөрдөж, төсвийн хөрөнгийг төсвийн захирагчийн шийдвэрээр захиран зарцуулж байх

6. Байгууллагын санхүүгийн тайланд 6 нэр төрлийн 24 тоо ширхэг, 5,650.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг хасах нэг жилээр бүртгэсэн, усны шланк, лед гэрэл зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн ангилал, ашиглах жилийг зөв залруулж бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан сургуулийн нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд бүртгэлтэй 2019 онд үүссэн 387.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулж ажиллах талаар арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	387.1	1	387.1								
Сургуулийн захиралд дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр утасны зардалд 112.0 мянган төгрөгийг төсвөөс олгосон байна.	1	112.0	1	112.0								
Жаргалант сумын сургуулийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 210 тоо толгой хонийг 13,230.3 мянган төгрөгөөр борлуулах, 1,520.0 мянган төгрөгийн 13 тоо толгой хонийг акталж устгахдаа сургуулийн захирал, байгууллагын өмч хамгаалах зөвлөл холбогдох шийдвэрүүдийг гаргаагүй байна.	1	14,750.3			1	14,750.3						
Тайлант онд сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардалд баталсан нормативыг хэтрүүлснээс төсвөөс 49.8 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.	1	49.8					1	49.8				
Эд хөрөнгийн тооллогын дүнг нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, сургуулийн захирлын 2022.06.15-ны өдрийн 46 дугаар тушаалаар 6,385.4 мянган төгрөгийн бараа материал актлах шийдвэр гарч бараа материал актлахдаа бараа материалыг устгасан акт үйлдээгүй байна.	1	6,385.4					1	6385.4				

"Боловсролын мэдээллийн технологийн төв" УТУГ-аас бүх сургууль, цэцэрлэгийн интернэтийн төлбөрийг төлсөн байхад 2022 онд гэр интернэтийн төлбөрт 3,125.0 мянган төгрөгийг давхардуулан төлсөн байна.	1	3,125.0					1	3125.0				
Байгууллагын санхүүгийн тайланд 6 нэр төрлийн 24 тоо ширхэг, 5,650.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг хасах нэг жилээр бүртгэсэн, усны шланк, лед гэрэл зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанарын хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.	1	5,650.1					1	5650.1				
Дүн	7	30,459.7	2	499.1	1	14,750.3	4	15,210.3	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант оны 10 дугаар сарын 5,500.0 мянган төгрөгийн малын үнэ болон аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 203,494.6 мянган төгрөгийн 5 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан, таван сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий орлого, зарлагыг мэдээлсэн, зарим тушаалын хавсралтыг мэдээлээгүй байна.	1	0					1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Сургуулийн захирлын 2022.12.15-ны өдрийн 102 дугаар тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай түвшнээр үнэлэгдээгүй сургуулийн сургалтын менежер, багш нар, нийгмийн ажилтан зэрэг 23 албан хаагчдад 4,136.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.	1	4136.6	1	4136.6				
БШУС-ын 2022.11.08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтад олгосон 37,465.0 мянган төгрөгийн санхүүжилтээс ерөнхий гэрээний дагуу "Техно зон" ХХК-аас 24,273.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, ерөнхий гэрээгүй байгуулаагүй "Тэнгэрийн уул" ХХК, "Арина компьютерс" ХХК, "Алтанбулаг үржих" ХХК-аас 13,361.6 мянган төгрөгийн үндсэн	1	13361.6			1	13,361.6		

хөрөнгийг гэрээ байгуулалгүйгээр худалдан авсан байна.								
Сургуулийн албан хаагчдад тайлант онд 21,852.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгох, аймаг, нийслэл рүү сургалтын зардалд шатахууныг олгохдоо сургуулийн захирал тушаал шийдвэр гаргаагүй, сургуульд тээврийн хэрэгсэл байхгүй, тээвэр шатахууны зардал батлагдаагүй байхад 7,986.2 мянган төгрөгийн шатахууныг 2022 онд олгосон байна.	1	29839.1					1	29839.1
Дүн	3	47,337.3	1	4,136.6	1	13,361.6	1	29839.1
Нийт дүн	4	47,337.3	1	4,136.6	1	13,361.6	2	29839.1

---oOo---